

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 32 ДУГААР ХУРАЛДААНЫ ТОЙМ

Хуралдаан 2013 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 14 цаг 03 минутад эхэлж, 14 цаг 55 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 52 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн зарим удирдах албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчдад Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> <ul style="list-style-type: none"><li>- Шүүхийн захиргааны удирдлагын газрын дарга</li><li>- Шүүхийн хүний нөөцийн газрын дарга</li><li>- Дотоод аудитын газрын дарга</li><li>- Шүүхийн санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга</li></ul>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд Батсүхийн Баярсайханд дүгнэлт гарган нэр дэвшүүлж, томилуулахаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн Н.Дагвад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “б”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн хүний нөөцийн газрын даргын</p>

		<p>албан тушаалд Лувсандоржийн Өлзийсайханд дүгнэлт гарган нэр дэвшүүлж, томилуулахаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн Н.Дагвад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>“Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн Дотоод аудитын албаны даргын, Шүүхийн санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан тушаалд нэр дэвшигчдийг сонгон шалгаруулж, нэр дэвшүүлэх боломжгүй гэсэн Комиссын дүгнэлтийг дэмжин, уг сонгон шалгаруулах захиалгыг Шүүхийн ерөнхий зөвлөлд буцаахаар шийдвэрлэв.</p>
2	<p>Дорноговь, Завхан, Төв, Өвөрхангай аймагт зохион байгуулсан төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2013 оны 11 дүгээр сарын 04-өөс 11 дүгээр сарын 21-ний өдрүүдэд Дорноговь, Завхан, Төв, Өвөрхангай аймагт тус тус зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Дорноговь, Завхан, Төв, Өвөрхангай аймагт 2013 оны 11 дүгээр сарын 04-өөс 11 дүгээр сарын 21-ний өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нийт 117 иргэнээс 73 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн</p>

		<p>жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц"-д, 44 иргэнийг "Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц"-д бүртгэснийг 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 дугаар хавсралтаар тус тус батлах.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан "Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц"-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 38 иргэнийг, "Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц"-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 17 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16 дугаар хавсралтаар тус тус батлах.</p> <p>3. Энэхүү тогтоолын 9-16 дугаар хавсралтаар баталсан нэр бүхий 55 иргэнийг "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Дорноговь, Завхан, Төв, Өвөрхангай аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргад үүрэг болгох.</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	--

3	Завхан аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн даргыг томилох тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Завхан аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргаар тус аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Дашпунцагийн Түвшинжаргалыг томилох.</p> <p>2. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн ажиллахыг Салбар зөвлөлийн дарга Д.Түвшинжаргалд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	Дархан-Уул аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 11 дүгээр сарын 21 -ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Дархан-Уул аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Амгалангийн Лхагважаргалыг томилох</p> <p>2. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 141 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 7-д "...Дагвасамбуугийн Болортуяа" гэснийг хүчингүй болсонд тооцох</p> <p>3. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэхийг Салбар зөвлөлийн</p>

		нарийн бичгийн дарга А.Лхагважаргалд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
5	Зарим албан хаагчдад төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулах тухай зэрэг дэв олгох тухай	Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйл, “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг батлах тухай” Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоолоор баталсан журмын 2, 6 дахь заалт “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журамд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын 2000 оны 20 дугаар тогтоолын 1-д заасны дагуу Төрийн өмчийн хорооны Төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, хяналтын газрын дарга Онгоодой овогтой Сэр-Одод төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн тэргүүн зэрэг дэв олгуулахаар санал ирүүлснийг хэлэлцээд, уг зэрэг дэвийг олгуулах саналыг Засгийн газарт уламжлахаар шийдвэрлэв.
6	Засгийн газрын тохируулагч агентлаг Цөмийн энергийн газрын Санхүү аж ахуйн хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	Засгийн газрын тохируулагч агентлаг Цөмийн энергийн газрын дарга Н.Тэгшбаярын 2013 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 1/1324 тоот албан бичиг, Цөмийн энергийн газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу сонгон шалгаруулалтыг 2013 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2013 оны 12 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулахаар тогтлоо.

## **ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**